

# Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2016 оны эхний 9 сарын байдлаар)



## I. Нийгмийн байдал

### I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 2016 оны 9 сард 315 байгаагийн 219 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 176 буюу 35.8 хувиар буурч, өмнөх сарынхаас 132 буюу 72.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Эхний 9 сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 98 ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх сараас өөрчлөлтгүй, өмнөх оны мөн үеэс 237 буюу 70.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



## II. Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 9 дүгээр сард 5300.3 сая төгрөг, зарлага 6652.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 116.7 сая төгрөг буюу 2.1 хувиар буурч, зарлага 283.1 сая төгрөг буюу 4.4 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 9 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 116.7 сая төгрөгөөр буурахад тэтгэврийн орлого 82.1 сая төгрөг буюу 2.3 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.



## III. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2016 оны эхний 9 сарын байдлаар 351 эх амаржиж 2015 оны мөн үетэй харьцуулахад 16 буюу 4.7 хувиар төрөлт нэмэгдсэн байна. Амьд төрсөн хүүхэд 354 үүнээс 175 нь хүү, 179 нь охин байна. Өмнөх оны мөн үеийнхээс амьд төрсөн хүүхэд 17 буюу 5.0 хувиар тус тус өссөн байна.

Он гарсаар 95536 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 13228 буюу 16.1 хувиар, 3738 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 374 буюу 11.1 хувиар тус тус өссөн байна.

## IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 9 сард 155 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 4 буюу 2.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 9 буюу 14.8 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэргийн тоо 23, гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 70 болсон нь илрээгүй гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхтэй ижил түвшинд, илрүүлэлтийн хувь өмнөх оны мөн үеийнхээс 6 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.



## V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2016 оны 9 дүгээр сард өмнөх сарынхаас 1.2 пунктээр, өмнөх оны мөн үеийнхээс 4.2 пунктээр, жилийн эцсийнхээс 3.7 пунктээр тус тус өссөн байна.



## VII. Орон нутгийн төсөв

2016 оны эхний 9 сарын байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 19285.4 сая төгрөг, гүйцэтгэлээр 19340.8 сая төгрөг болж нь өмнөх оны мөн үеийнхээс төсвийн орлогын гүйцэтгэл 9746.3 сая төгрөг буюу 2.0 дахин өсчээ. Аймгийн төсвийн нийт зарлага 12493.6 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 10261.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 2231.8 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Төсвийн нийт зарлага өмнөх оны мөн үеийнхээс 685.4 сая төгрөг буюу 7.2 хувиар өссөн байна. 2016 оны эхний 9 сарын байдлаар авлагын үлдэгдэл 0 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 462.5 сая төгрөг байна.



## VIII. Мал аж ахуй

Аймгийн хэмжээнд 2015 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 171188 хээлтэгч малын 150604 буюу 88.0 хувь нь 2016 оны 9 дүгээр сарын байдлаар төллөсөн байна. Эм хонины 92.0 хувь, эм ямаа 86.3 хувь, үнээний 76.7 хувь, ингэний 52.4 хувь, гүүний 67.0 хувь нь төллөсөн бөгөөд 2016 оны 9 сарын байдлаар 148445 толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 17123 толгойгоор өссөн үзүүлэлттэй байна.



## VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт гаргалт 2016 оны эхний 9 сард 30944.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 4560.6 сая төгрөг буюу 17.3 хувиар өссөн ба үүнд уул уурхайн салбарын гаргалт нь 4526.5 сая төг буюу 17.9 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 29070.9 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2686.7 сая төгрөг буюу 12.7 хувиар өслөө.



## IX. ТЭЭВЭР

Авто тээврийн үндэсний төвийн 2016 оны эхний 9 сарын мэдээгээр 17.3 мянган зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 3995.1 мян.хүн км болж, 13 ажилтантай 10.7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.